



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны ᠐1 сарын 1᠖ өдөр

Дугаар ᠑/᠒᠐

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6᠐ дугаар зүйлийн 6᠐.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэвшүүлсэн хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний хүрээнд санал боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга) (зөвшилцсөнөөр)
 (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
 (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
 (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
 (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
 (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
 (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
 (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
 (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

2.

- (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
- (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
- (Онцгой байдлын газрын дарга)
- (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- (Эрүүл мэндийн газрын дарга)
- (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
- (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- (Соёл, урлагийн газрын дарга)
- (Нэгдсэн эмнэлгийн орлогч дарга)
- (Татварын хэлтсийн дарга)
- (“Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ-ын захирал)
- (Улаан загалмайн хорооны дарга)
- (Иргэний нийгмийн нэгдсэн зөвлөлийн дарга)
- (Есөнбулаг сумын Засаг дарга бөгөөд Алтай хотын захирагч)
- (Сумдын Засаг даргын орлогч нар)
- (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга:

2. Дэд ажлын хэсгийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг баталж, үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Цогц арга хэмжээний саналаа хууль тогтоомж, бодлогын холбогдох баримт бичигт нийцүүлэн боловсруулж, зохих шийдвэрийн төслийг танилцуулахыг дэд ажлын хэсэгт даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/677 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР